



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН
ЗӨВЛӨМЖ

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

"Төв цэнгэлдэх хүрээлэн" ХХК-ийн
2025 оны үйл ажиллагааны үр дүнг үнэлж
дүгнэсэн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам" А/1106 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх тухай" А/1843 дугаар захирамжийг тус тус үндэслэл болгов.

Танай байгууллага нь Нийслэлийн Засаг даргын 2026 оны "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2025 оны үйл ажиллагааны үр дүнг дүгнэх тухай" А/233 дугаар захирамжаар "Хангалттай" гэж үнэлэгдсэн бөгөөд үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг нийт хуулийн этгээдийн дундажтай харьцуулахад бодлогын үр дүнгийн 5 шалгуур үзүүлэлт 4.8 хувиар дээгүүр, чиг үүргийн үзүүлэлтийн дүнгийн 10 шалгуур үзүүлэлт 6.5 хувиар доогуур, үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээний 3 шалгуур үзүүлэлт 11.9 хувиар доогуур үзүүлэлттэй байна.

Цаашид дараах зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдье. Үүнд:

1.Бодлогын баримт бичиг болон хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 43, 183 дугаар тогтоолоор батлагдсан журмуудыг тус тус баримтлах;

2.Бодлогын баримт бичиг, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг урьдчилан тодорхойлсон хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийн дагуу нотлох баримтад үндэслэн үнэн, зөв тайлагнаж, холбогдох нотлох баримтыг хавсаргах;

3.Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүрэг даалгаврыг бүрэн хэрэгжүүлж, хугацаанд нь нотлох баримтын хамт тайлагнаж хэвших;

4.Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 521 дүгээр тогтоолын дагуу хувийн хэргийн бүрдлийг шинэчилж, шаардлагатай баримт бичгийг бүрэн хавсаргах;

5.Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтмол үнэлж, ажилтнуудын сэтгэл ханамж, үр дүнг хэмжих тогтолцоог бий болгох;

6.Сургалтын дараах үнэлгээ, үр дүнгийн тайланг гаргаж, хүний нөөцийн хөгжлийн бодлоготой уялдуулах;

7.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдөж, баримт бичгийг MNS 5140.2021 стандартын шаардлагад нийцүүлэх,

1726320135

8. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жил бүр Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулах;

9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын хавсралтад заасан маягт (Маягт 1, 2, 3)-ын дагуу төлөвлөж, хэрэгжилтийг тайлагнах;

10. Худалдан авах ажиллагаатай холбоотой тендерийн баримт бичгийг холбогдох хууль, журамд нийцүүлэн бүрэн бүрдүүлж, архивын нэгж бүрдүүлэх;

11. Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж төсвийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахад анхаарах;

12. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу "Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна" гэж заасны дагуу тендер шалгаруулалтын аргыг сонгох;

13. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэгт заасны дагуу Гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэх тохиолдолд "Гэрээ шууд байгуулах тухай зарлалыг бараа, ажил, үйлчилгээний ерөнхий мэдээллийн хамт цахим системд нийтэлж, энэ хуулийн 54.8-д зааснаар аж ахуй эрхлэгчид хэлэлцээ хийх урилга хүргүүлнэ" гэж заасныг баримталж ажиллах;

14. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.1-д заасны дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэх буюу анхан шатны баримтын иж бүрдлийг хангасны үндсэн дээр төлбөр тооцоог гүйцэтгэх; (Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог ойлгоно.)

15. Аудитын зөвлөмжийг тогтоосон хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг хүргүүлэх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах;

16. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон холбогдох стандартын шаардлагыг хангаж, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийж, ажлын төлөвлөгөө, дотоод журмыг баталж мөрдөх, үр дүнг тооцох, тайлагнах;

17. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Засгийн газрын 2026 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан "Цахим хуудас хөтлөх, ил тод, нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам", "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам"-ын хэрэгжилтийг хангуулж, холбогдох мэдээллийг тухай бүр шинэчилж, байгууллагын албан ёсны цахим хуудас болон бусад мэдээллийн сувгаар дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах;

18. Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны мэдээллийг <https://shilendans.gov.mn> цахим системд хуульд заасан хугацаанд нь байршуулан, мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг хангаж ажиллах;

19. Зөвлөмжийн хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тайлагнах.


ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА

Б.МӨНХБАЯР

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын
 2026 оны 03 дугаар сарын 20-ны
 өдрийн 45 дугаар зөвлөмжийн
 хавсралт



Тус байгууллагын үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг нийт хуулийн этгээдийн дундажтай харьцуулсан үзүүлэлт:



Үзүүлэлт	Хуулийн этгээдийн дундаж үзүүлэлт	Танай байгууллагын үзүүлэлт	Зөрүү
А. Бодлогын үр дүн	86.4	91.2	4.8
Б. Чиг үүргийн үзүүлэлтийн дүн	85.6	79.1	-6.5
В. Үйл ажиллагааны ил тод байдлын үнэлгээ	88.1	76.2	-11.9